



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2002 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 369

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

ТУШААХ нь:

Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Гэрээний загвар, заавар батлах тухай” 355 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэлийн Засаг дарга болон төсвийн ерөнхийлөн захирагчийн хооронд бүтээгдэхүүн нийлүүлэх төсвийн санхүүжилтийн гэрээ”-ний үлгэрчилсэн загварыг энэхүү тушаалын хавсралтын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулан баталсугай.



*Ч.Улаан*  
САЙД Ч.УЛААН



Сангийн сайдын 2007 оны  
тоот тушаалын хавсралт

**АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН ЗАСАГ ДАРГА БОЛОН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН  
ЗАХИРАГЧИЙН ХООРОНД БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭЛТ, САНХҮҮЖИЛТИЙН  
ТАЛААР БАЙГУУЛАХ ҮЛГЭРЧИЛСЭН ГЭРЭЭ**

Энэхүү гэрээг нэг талаас Захиалагч:

\_\_\_\_\_ (төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх  
салбар, албан тушаалын нэр)

\_\_\_\_\_ (төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр)

Нөгөө талаас Бүтээгдэхүүн нийлүүлэгч:

\_\_\_\_\_ аймаг (нийслэл)-ийн

Засаг дарга \_\_\_\_\_ (аймаг (нийслэл)-ийн Засаг даргын нэр)

Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон Монгол Улсын 200... оны төсвийн тухай хуулиар тухайн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тусгагдсан үзүүлэлтүүдийг үндэслэн, хэлэлцэн тохиролцож энэхүү гэрээг 200...оны ....дугаар сарын .....-ны өдөр байгуулав.

**АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН ЗАСАГ ДАРГА БОЛОН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН  
ЗАХИРАГЧИЙН ХООРОНД БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭЛТ, САНХҮҮЖИЛТИЙН  
ТАЛААР БАЙГУУЛАХ ҮЛГЭРЧИЛСЭН ГЭРЭЭ**

200.. оны .....дугаар  
сарын .....-ны өдөр

Дугаар

Улаанбаатар  
хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний зорилго нь \_\_\_\_\_ аймаг, нийслэлийн Засаг даргаас \_\_\_\_\_-ийн сайдын худалдан авах бүтээгдэхүүний стратегийн ач холбогдол, тоо хэмжээ, чанар улсын төсвийн санхүүжилтийн хэмжээг тодорхойлох, бүтээгдэхүүн нийлүүлэх талаар \_\_\_\_\_-ийн сайд, Засаг даргын харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, эцсийн үр дүнг үнэлж, дүгнэх замаар тус аймаг /нийслэл/-д үзүүлэх \_\_\_\_\_ төрийн болон нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

1.2. “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 23.1, 51.1.8 дахь заалт, Иргэний хуулийн 95-205 дахь заалтыг үндэслэн төсвийн байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг санхүүжүүлэх зарчмыг удирдлага болгон нэг талаас \_\_\_\_\_-ийн сайд \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_, нөгөө талаас \_\_\_\_\_ аймаг, нийслэлийн Засаг дарга \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нар 200.. оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 200... оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулж 3 хувь үйлдэв.

1.3. Уг гэрээнд Төсвийн ерөнхийлөн захирагч Засаг даргаас улсын төсвийн санхүүжилтээр захиалж, худалдан авах бүтээгдэхүүн болон Засаг даргаас эрхлэн нийлүүлэх бүтээгдэхүүн, ажлын үр дүнд тавих шаардлага, гэрээний биелэлтийг дүгнэх болзол, бусад нөхцөлийг тусгав.

1.4. Гэрээнээс гадуур орсон орлогыг “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” хуулийн 13-ын 13.3, 13.4 дэх заалтын дагуу зарцуулна.

1.5. \_\_\_\_\_-ийн сайд, \_\_\_\_\_ аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан энэхүү гэрээтэй холбогдох харилцааг Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, тухайн салбарын үйл ажиллагааг зохицуулах хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

Хоёр. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг

2.1. Төсвийн ерөнхийлөн захирагч болох \_\_\_\_\_-ийн сайд нь дараахь үүрэг хүлээнэ:

а/ Сайдын нэрийн өмнөөс \_\_\_\_\_ нэр төрлийн бүтээгдэхүүн худалдаж авахад \_\_\_\_\_ сая төгрөгийн зардал гарахаас \_\_\_\_\_ сая төгрөгийн санхүүжилтийг төсвөөс олгоно; (Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хувьд гүйцэтгэгчийг шалгаруулах тендерээр авсан үнийн дүнгийн хэмжээгээр санхүүжилт олгоно.)

б/ Өмчлөгчийн дэвшүүлэх бусад \_\_\_\_\_ зорилт буюу нэмэлт бүтээгдэхүүн худалдан авахад \_\_\_\_\_ сая төгрөгийн санхүүжилтийг бусад эх үүсвэрээс олгох;

в/ Гэрээний нөхцөлийг хэрхэн биелүүлж байгаад харилцан хяналт тавьж, ажил төрлийн талаар байнгын уялдаатай ажиллах.

г/ Засаг даргаас нийлүүлэх бүтээгдэхүүний үйл ажиллагааны үр дүнгийн төлөөх эцсийн хариуцлагыг Төсвийн ерөнхийлөн захирагч ажлаа тайлагнадаг дээд шатны байгууллагын өмнө хариуцна.

Гурав. Засаг даргын үүрэг

3.1. \_\_\_\_\_ аймаг, нийслэлийн Засаг дарга миний бие нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 52.1.2 болон \_\_\_\_\_ хуулийн \_\_\_\_\_ заалтын дагуу энэхүү гэрээнд заагдсан бүтээгдэхүүн нийлүүлэх үүрэг хүлээж, түүний үр дүнг \_\_\_\_\_-ийн сайдын өмнө хариуцна.

3.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан \_\_\_\_\_ салбарын зорилтуудыг хангуулах, удирдлага, зохицуулалтыг эрхэлж, арга зүй, зохион байгуулалтын шуурхай удирдлагаар хангах үйл ажиллагааг өөрийн аймаг, нийслэлд явуулна.

3.3. Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэх бүтээгдэхүүн болон түүний зарим хэсгийг гуравдагч этгээдээр (тухайн салбарт үл хамаарах төсвийн байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж гэх мэт) гүйцэтгүүлэхээр хариуцан гэрээлсэн бол тэдгээрийг тогтоосон хугацаанд нийлүүлэх асуудлыг Засаг дарга хариуцна.

3.4. Улсын төсвийн хөрөнгөөр бүтээгдэхүүн нийлүүлэх энэхүү гэрээ, түүний санхүүжилт, харилцан хүлээх үүрэг хариуцлагын талаар ТБУСТХ-ийн 50.1.4-т заасны дагуу Иргэдийн төлөөлөгчдийн хуралд оруулж хэлэлцүүлэн санал дүгнэлтийг нь авна.

3.5. Үйл ажиллагааны зардлын хэмнэлт /Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 13.7 дахь заалт/-ийг, \_\_\_\_\_-ийн сайдтай зөвшилцсөний үндсэн дээр хуульд заасны дагуу төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан зарцуулна.

3.6. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 12, 51 дүгээр зүйлүүдэд тусгагдсаны дагуу Засаг дарга гэрээний хугацаанд сайдын өмнө дараахь үүрэг гүйцэтгэнэ:

а/ энэхүү гэрээний нөхцөлийн дагуу бүтээгдэхүүн нийлүүлнэ;

б/ өөрийн аймаг /нийслэл/-ийн засаг захиргааны өмчлөгчийн эрх ашгийг хамгаалж хэрэгжүүлнэ;

в/ улсын төсвийн хөрөнгөөр бүтээгдэхүүн нийлүүлэх талаар сум, дүүргийн Засаг дарга нартай бүтээгдэхүүн худалдан авах гэрээ болон тухайн салбарын байгууллагын ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана

г/ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн сайдын 2002 оны.....тоот тушаалаар баталсан журам, маягтын дагуу бүтээгдэхүүн нийлүүлэлтийн улирал, жилийн тайланг ТБУСТХ-ийн 39, 40 дүгээр зүйлд заасны дагуу үнэн зөв гаргаж захиалагч төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Дөрөв. Улсын төсвийн санхүүжилт, төлбөрийн нөхцөл

4.1. Засаг даргын нийлүүлсэн бүтээгдэхүүний санхүүжилт нь бүтэн жилийн урьдчилан тохиролцсон өртөг байх бөгөөд түүний төлбөрийг энэхүү гэрээний 2 дугаар хавсралтад тусгагдсан хуваарийн дагуу Төрийн нэгдсэн сангаар дамжуулан гүйцэтгэгдэнэ.

4.2. Сангийн яамны Төрийн сангийн газар энэхүү гэрээний 4.1-д заасан хуваарийн дагуу бүтээгдэхүүний санхүүжилтийн төлбөрийг \_\_\_\_\_ аймаг/нийслэл/-ын Засаг даргын захиран зарцуулах эрх бүхий Төрийн сангийн хэлтсийн дансанд сар бүрийн тогтсон хуваариар шилжүүлэх үүрэг хүлээнэ.

4.3. \_\_\_\_\_ аймаг /нийслэл/-ын Төрийн сангийн хэлтэс нь улсын төсвийн байгууллага тус бүрийн санхүүжилтийг төсвийн дансанд ажлын 3 өдөрт багтаан гүйцэтгэнэ.

4.4. \_\_\_\_\_-ын сайдын нэрийн өмнөөс \_\_\_\_\_ аймаг /нийслэл/-ын Засаг даргын бүтээгдэхүүний санхүүжилтийн төлбөрийг Төсвийн ерөнхийлөн захирагчтай тохиролцон баталсан хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн газраас санхүүжүүлнэ. Энэ тохиолдолд энэхүү гэрээний 4.2, 4.3 дахь заалт нэгэн адил хүчинтэй.

4.5. "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай" хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Засаг даргаас эрхлэн сар бүрийн санхүүгийн тайлан, улирал бүрийн эцэст бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайлан гаргаж тухайн салбарын яам, Сангийн яамны Төрийн сангийн газарт ирүүлнэ.

4.6. Засаг дарга тодорхой нэрийн бүтээгдэхүүнийг хугацаанд нь нийлүүлээгүй бол тухайн бүтээгдэхүүнийг захиалагч болон Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн сайд түүний төлбөрийг хийх үүрэг хүлээхгүй, ирүүлсэн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланд хийсэн үнэлгээгээр гэрээнд тусгагдсан тоо хэмжээ, чанарын үзүүлэлтийг бүрэн хангаагүй бол дараагийн улирал, жилийн бүтээгдэхүүний төлбөрийг зохих журмын дагуу бууруулан зохицуулж болно.

Тав. Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, төлбөрийн нөхцөл

5.1. Энэхүү гэрээний 2"а" хавсралт дахь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Засаг даргын Тамгын газар зохион байгуулна.

5.2. 2"а" хавсралтад тусгагдсан төсөл, арга хэмжээний зураг, төсвийг бэлэн болгож, гүйцэтгэгч шалгаруулах тендерийг эрх шилжүүлэн авсан Засаг даргын Тамгын газар 2008 оны 3 сарын 1-ний дотор зарлан дүгнэж, гэрээ байгуулах арга хэмжээ авна.

5.3. 2"а" хавсралтад дурдсан хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гэрээнд заасан дүнгээр нь Сангийн яамны Төрийн сангаас аймаг, нийслэлийн төрийн санд батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлнэ.

5.4. Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 318 дугаар тогтоолоор байгуулсан "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" нь 2"а" хавсралтад дурдсан төсөл арга хэмжээний техникийн болон гүйцэтгэлийн хяналтыг хариуцан хэрэгжүүлнэ.

5.5. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба"-тай гэрээ байгуулан ажиллах бөгөөд захиалгат барилга байгууламжийн техник хяналтын зардлаар барилга захиалагчийн албаны техник няналтын үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга захиалагчийн техник хяналтын зардлыг зөвхөн зориулалтын дагуу ашиглуулж тусгай тайлан баланс гаргаж ажиллана.

5.6. Сангийн яамны Төрийн сангийн газраас аймаг, нийслэлийн Төрийн сангийн хэлтсийн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын дансанд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг сар бүрийн эхний /ажлын/ 3 хоногт багтаан хуваарийн дагуу олгоно. Санхүүжилтийг олгохдоо хөрөнгө оруулалт, их засвар, тоног төхөөрөмжийн хөрөнгийн хэмнэлтийг хасаж тооцно. Хөрөнгө оруулалт, их засвар, тоног төхөөрөмжийн хэмнэлтийг зарцуулж болохгүй.

5.7. Засаг даргаас эрхлэн сар бүрийн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн тайланг хавсралт 2"б" маягтын дагуу гаргаж, дараа сарын 3-ны өдрийн дотор салбарын яам, Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн санд тус тус хүргүүлнэ.

5.8. Аймаг, нийслэлийн Төрийн сангаас хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын ажлын батлагдсан төсөл арга хэмжээг санхүүжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

- а. Хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын санхүүжилтийг УИХ-аар батлагдсан төсөл, арга хэмжээ нэр төрөл бүрээр, эдийн засгийн ангилал, батлагдсан хөрөнгийн хүрээнд санхүүжүүлнэ.
- б. Хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын ажлыг зохих журмын дагуу хянагдаж батлагдсан гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлнэ.
- в. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд зураг төсөв, захиалагчийн хяналтын зардлын дүнг тусгаж, барилгын гүйцэтгэл, зураг төсөв, геологийн зардлыг гүйцэтгэгчид, захиалагчийн хяналтын зардлыг аймгийн ЗДТГ-т тус тус салгаж санхүүжүүлнэ.

5.9. "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ажлын гүйцэтгэлийг хянаж, баталгаажуулан ЗДТГ-ын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлнэ. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн хянаж, санхүүжилтийн мэдэгдлийг аймгийн Санхүү, эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтсийн даргаар баталгаажуулан Төрийн санд хүргүүлнэ.

5.10. Аймаг, нийслэлийн Төрийн сан нь санхүүжилтийн мэдэгдэл, гүйцэтгэгчийн нэхэмжлэх, бусад материалыг үндэслэн хянаж санхүүжүүлэх үйл ажиллагааг ажлын 2 хоногт багтаан гүйцэтгэнэ.

5.11. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, ажлын явц, үр дүнг олон нийтэд нээлттэй, ил тод сурталчилах, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

#### Зургаа. Гэрээг дүгнэх, үнэлэх

6.1. Төсвийн ерөнхийлөн захирагч гэрээний биелэлтийг дараа оны 2-р сард багтаан дүгнэнэ.

6.2. Захиалагч нь бүтээгдэхүүн нийлүүлэлтийн улирлын тайланд дүгнэлт хийж, жилийн тайланд нарийвчилсан үнэлгээ хийнэ. Нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанарыг дараахь арга хэлбэрээр үнэлнэ.

а. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрөө үнэлэх;

б. Шаардлагатай бол тусгайлсан мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэх;

#### Долоо. Гэрээгээр харилцан хүлээх үүрэг

7.1. Гэрээнд тусгагдсан үүргээ харилцан биелүүлнэ:

7.1.1. Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн энэхүү гэрээнд хамаарах заалтуудыг баримтлан ажиллах,

7.1.2. Хугацаа хожимдуулсан, тасалдуулсан, чанаргүй бүтээгдэхүүн гаргахгүй байх,

7.1.3. Гэрээт бүтээгдэхүүн, үйлчилгээний санхүүжилтийг тасалдалгүй тогтсон хуваарийн дагуу явуулах арга хэмжээ авч ажиллах,

7.1.4. Шаардлага гарсан нөхцөлд харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрээг цуцлах,

#### Найм. Маргааныг шийдвэрлэх

8.1. Гэрээг байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлэхдээ:

8.1.1. Нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хугацаа, чанартай холбогдон үүссэн асуудлыг аль болох харилцан зөвшилцлийн дагуу шийдвэрлэж байх,

8.1.2. Бүтээгдэхүүний өртгийг тодорхойлох, бүтээгдэхүүний төлбөрийг шилжүүлэхтэй холбогдон үүссэн асуудлыг санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандаж зохицуулах арга хэмжээ авч байх.

8.1.3. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль эрх зүйн холбогдолтой асуудлаар шаардлагатай гэж үзвэл хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандаж зөвлөгөө авч ажиллах.

Ес. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах

9.1. Гадаад, дотоод орчин өөрчлөгдсөнөөс гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд хоёр тал бичгээр санал тавьж, харилцан зөвшилцөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.2. Гэрээний өөрчлөлтийг тухай бүрд нь бичгээр үйлдэн \_\_\_\_\_-ийн сайд, Засаг дарга нар гарын үсэг зурж, гэрээний анхны эх хувьд хавсаргана. Гэрээний анхны болон өөрчилсөн эхүүдийн хувь тус бүрийг \_\_\_\_\_-ийн сайд болон Засаг дарга хадгална. Гэрээний 1 хувийг Сангийн яаманд хүргүүлнэ.

9.3. Гэрээнд тусгагдаагүй бүтээгдэхүүн нийлүүлэх асуудлыг талууд харилцан зөвшилцөж санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулсаны үндсэн дээр нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэж болно.

9.4. \_\_\_\_\_-ийн сайд гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж, дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор багтаан энэхүү гэрээг дүгнэж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлнэ.

Арав. Гэрээнд оролцогч талуудын гарын үсэг

10.1. \_\_\_\_\_ аймаг, нийслэлийн Засаг дарга миний бие Гэрээ, түүний хавсралтуудыг \_\_\_\_\_-ийн сайдтай хэлэлцэж тохирсон болно.

10.2. Гэрээг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд түүнийг хэрэгжүүлэх явцад дараахь асуудалд онцгой анхааран ажиллах болно. Үүнд:

а/ Гэрээний хавсралтад дурьдсан стратегийн зорилтуудыг биелүүлэх, бүтээгдэхүүнийг нийлүүлэх, өмчлөгчийн үйл ажиллагааны зорилтуудыг биелүүлэх;

б/ Гэрээнд заасан тайлан, бусад мэдээг \_\_\_\_\_-ийн сайдад тогтоосон хугацаанд нь гаргаж өгнө.

\_\_\_\_\_ аймаг, нийслэлийн Засаг дарга \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_  
\_\_\_\_\_ /гарын үсэг/

10.3. \_\_\_\_\_-ийн сайд миний бие гэрээ түүний хавсралтуудыг Засаг дарга \_\_\_\_\_-тай тохиролцсон бөгөөд ЗГХЭГ, Төсвийн бусад холбогдох ерөнхийлөн захирагч нартай зөвлөлдсөний үндсэн дээр гарын үсэг зурж байна.

10.4. Гэрээг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд түүнийг хэрэгжүүлэх явцад дараахь асуудалд онцгой анхааран ажиллах болно.



а/ бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгасан бүтээгдэхүүнийг тохиролцсон үнээр худалдан авна;

б/ нийлүүлэгдсэн бүтээгдэхүүний төлбөрийг түүний нийлүүлэлтийн явцыг харгалзан Сангийн яамтай тохиролцсон хуваарийн дагуу \_\_\_\_\_ аймаг, нийслэлийн Засаг даргад шилжүүлэх;

в/ \_\_\_\_\_-ийн сайдын нэрийн өмнөөс .....аймаг, нийслэлийн Засаг даргын худалдан авах бүтээгдэхүүний төлбөрийг Сангийн яамтай тохиролцсон хуваарийн дагуу хийх.

Тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхэлсэн салбар болон аймаг /нийслэл/-ийн онцлогтой уялдан энэхүү нийтлэг гэрээнд дараахь зүйлийг нэмж тусгав. Үүнд:

- 1. \_\_\_\_\_
- 2. \_\_\_\_\_
- 3. \_\_\_\_\_

\_\_\_\_\_ -ийн сайд \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_

\_\_\_\_\_ /гарын үсэг/ 200 он.....сар..... өдөр

Аймаг /нийслэл/-ийн Засаг дарга болон төсвийн ерөнхийлөн захирагчийн хооронд бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулах үлгэрчилсэн гэрээний Хавсралт № 1

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газраас дэвшүүлж байгаа богино болон дунд хугацааны стратегийн зорилтууд

\_\_\_\_\_ /аймаг, нийслэлийн нэр/ аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр дэх \_\_\_\_\_ /ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний нэр/ үйл ажиллагаа нь 200.... -200..... онд Засгийн газрын дараахь стратегийн зорилтыг хангахад чиглэгдэнэ. Үүнд:

- Стратегийн зорилт 1
- Стратегийн зорилт 2
- Стратегийн зорилт 3
- Стратегийн зорилт 4
- Стратегийн зорилт 5 гэх мэт.

#### ТЕЗ-ийн үйл ажиллагааны хамрах хүрээ

\_\_\_\_\_ (ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний нэр)-ийн чиглэлээр \_\_\_\_\_ (аймаг, нийслэлийн нэр) аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт дараахь үйл ажиллагааг явуулна:

#### (Аймаг/ нийслэлийн нэр) аймаг, нийслэлийн гадаад дотоод орчны шинжилгээ

\_\_\_\_\_ (аймаг, нийслэлийн нэр) аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт \_\_\_\_\_ (ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний нэр)-ийн үйл ажиллагаа дараахь онцлогийг агуулна:

2. Төсвийн жилд Засаг даргын нийлүүлэх бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний ангийн жагсаалт:

Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт оршин байгаа \_\_\_\_\_ /ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний нэр/ байгууллага, сум, дүүргээс нийлүүлэх бүтээгдэхүүнийг тодорхойлсон байна.

Бүтээгдэхүүний анги 1: \_\_\_\_\_ үйлчилгээ/бүтээгдэхүүний ангийн нэр/

Томъёолол

Энэхүү бүтээгдэхүүний анги нь \_\_\_\_\_ (төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээ) эрхлэх асуудлын хүрээнд \_\_\_\_\_ (бүтээгдэхүүний ангид хамаарах гол) зэрэг үйл ажиллагааг хамарна.

Шалгуур үзүүлэлт	Бүтээгдэхүүний өртөг зардал /мянган төгрөг/
Тоо хэмжээ	
Чанар, үр дүн:	
Хугацаа:	

**Бүтээгдэхүүний анги 2:** \_\_\_\_\_ үйлчилгээ /бүтээгдэхүүний ангийн нэр/

Томъёолол

Энэхүү бүтээгдэхүүний анги нь \_\_\_\_\_ төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээ) эрхлэх асуудлын хүрээнд \_\_\_\_\_ (бүтээгдэхүүний ангид хамаарах гол) зэрэг үйл ажиллагааг хамарна.

Шалгуур үзүүлэлт	Бүтээгдэхүүний өртөг зардал /мянган төгрөг/
Тоо хэмжээ	
Чанар, үр дүн:	
Хугацаа:	

Аймаг /нийслэл/-ийн Засаг дарга болон төсвийн ерөнхийлөн захирагчийн хооронд бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулах үлгэрчилсэн гэрээний Хавсралт № 2

Төсвийн ерөнхийлөн захирагч \_\_\_\_\_-ны сайдад \_\_\_\_\_ аймаг, нийслэлийн Засаг даргын нийлүүлсэн бүтээгдэхүүний төлбөрийг шилжүүлэх хуваарь

Төсвийн ерөнхийлөн захирагчийн Төрийн сангийн нэгдсэн сан дахь дансны дугаар № \_\_\_\_\_,

Бүтээгдэхлүүн нийлүүлэгч \_\_\_\_\_ аймаг, нийслэлийн Засаг даргын \_\_\_\_\_ аймаг, нийслэл дэх төрийн сангийн дансны дугаар № \_\_\_\_\_

/мянган төгрөг/

№	Санхүүжилтийн нэр, агуулга*	.....оны сар, улирал	Олгох санхүүжилт
1.	Урсгал санхүүжилт	1-р сар	
2.	Хөрөнгө оруулалтын санхүүжилт	2-р сар	
3.	Үр дүнгийн санхүүжилт гэх мэт	3-р сар	
		Улирлын дүн	
		4-р сар	
		5-р сар	
		6-р сар	
		Улирлын дүн	
		7-р сар	
		8-р сар	
		9-р сар	
		Улирлын дүн	
		10-р сар	
		11-р сар	
		12-р сар	
		Улирлын дүн	
	Дүн	Жилийн дүн	

Санхүүжилтийн хуваарийг хянаж, зөвшөөрсөн \_\_\_\_\_ яамны Төрийн нарийн бичгийн дарга \_\_\_\_\_

Боловсруулсан: \_\_\_\_\_ газрын мэргэжилтэн \_\_\_\_\_

200....оны ....дугаар сарын .....-ны өдөр

Аймаг (нийслэл)-ын Засаг дарга болон төсвийн ерөнхийлөн захирагчийн хооронд бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан нийтлэг гэрээний Хавсралт №2”а”

**а/Аймаг, нийслэлд эрх шилжүүлэх хөрөнгө оруулалт**

Төсвийн ерөнхийлөн захирагч . . . . . сайдын 2008 оны санхүүгийн жилд хэрэгжүүлэх доорх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг . . . . . аймгийн Засаг даргын мэдэлд гэрээгээр эрх шилжүүлэхийг зөвшөөрөв.

Төсвийн ерөнхийлөн захирагч .....сайд ..... / /

**.....аймагт 2008 оны санхүүгийн жилд хэрэгжүүлэх .....яамны захиалгатай хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт**  
/сая.төгрөг/

дл	Төсөл , арга хэмжээний нэр, байршил	Хэрэгжүүлэх хугацаа	Төсөвт өртөг	2008 онд санхүүжүүлэх хэмжээ
	<b>I.Хөрөнгө оруулалт:дүн</b>			
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр			
1				
2				
3				
4				
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр			
1				
2				
3				
	<b>II. Их засвар:дүн</b>			
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр			
1				
2				
3				
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр			
1				
2				
3				
	<b>III.Тоног төхөөрөмж: дүн</b>			
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр			
1				
2				
3				
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр			
1				
2				
3				
	Бүгд			

**б/Аймаг, нийслэлд эрх шилжүүлэх хөрөнгийн оруулалтын  
санхүүжилтийн хуваарь**

Сангийн яамны Төрийн сангийн газраас бүтээгдэхүүн нийлүүлэгч .....аймгийн Төрийн сангийн дансанд шилжүүлэх хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хуваарь.

.....Ховд аймгийн Төрийн сангийн дансны дугаар№.....  
Хөрөнгө оруулалтын дансны дугаар№.....  
Их засварын ажлын дансны дугаар№.....  
Тоног төхөөрөмжийн дансны дугаар№.....

.....аймагт 2008 оны санхүүгийн жилд хэрэгжүүлэх .....яамны захиалгатай хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний  
санхүүжилтийн хуваарь

/сая.төгрөг/

дд	2008 онд Санхүүжүүлэх хэмжээ	Үүнээс:																
		1-р сар	2-р сар	3-р сар	1 Улирал	4-р сар	5-р сар	6-р сар	II улирал	7-р сар	8-р сар	9-р сар	III улирал	10-р сар	11-р сар	12-р сар	IV улирал	
	<b>I.Хөрөнгө оруулалт: дүн</b>																	
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр																	
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр																	
	<b>II. Их засвар: дүн</b>																	
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр																	
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр																	
	<b>III. Тоног төхөөрөмж: дүн</b>																	
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр																	
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр																	
	<b>Бүгд</b>																	

Аймагт шилжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр төрлийн жагсаалт, санхүүжүүлэх хөрөнгийн сарын хуваарыг хянаж зөвшөөрсөн:

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ..... /  
..... яамны Төрийн нарийн бичгийн дарга. .... /

84

Аймаг (нийслэл)-ын Засаг дарга болон төсвийн ерөнхийлөн захирагчийн хооронд бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан нийтлэг гэрээний Хавсралт №2 “б”

Аймаг, нийслэлд эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

Батлав: .....аймгийн Засаг дарга ..... /

ТЕЗ яам, газруудын захиалгаар 2008 оны санхүүгийн жилд ..... аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл /....-р сарын мэдээ, сая.төгрөг/

дл	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хэрэг-жүүлэх Хугацаа	Гэрээний дугаар	гэрээнд тусгасан төсөвт өртөг	2008 онд санхүүжүүлэх батлагдсан хэмжээ	Санхүүжилтийн гүйцэтгэл өссөн дүнгээр	Объектын ажлын явцын талаарх товч тайлбар
а	<b>Б</b>	1	2	3	4	5	6
	<b>а/БСШУЯам</b>						
	<b>I.Хөрөнгө оруулалт:дүн</b>						
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр						
1							
2							
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр						
1							
2							
	<b>II. Их засвар:дүн</b>						
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр						
1							
2							
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр						
1							
2							
	<b>III.Тоног төхөөрөмж: дүн</b>						
	Үүнээс: А.Улсын төсвийн хөрөнгөөр						
1							
2							
	В.Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр						
1							
2							
	<b>Бүгд</b>						
	<b>б/ХХААЯам</b>						
	<b>в/НХХЯам</b>						
	<b>г/ЭМЯам ГЭХ МЭТ</b>						
	<b>Бүгд дүн</b>						

\*Гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 03-ны өдрийн дотор гаргаж ТЕЗ-чид болон Сангийн яамны ТБЗГ, ТСГ-г хүргүүлнэ.

Гүйцэтгэл хянаж боловсруулсан ..... аймагийн:

1. СЭЗБЗХэлтсийн дарга ..... /

2. Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн. .... /

3. Төрийн сангийн мэргэжилтэн ..... /

2008 оны .... дугаар сарын ... .ны өдөр